

ДУНДГОВЬ АЙМАГ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЧМЭЛ ТАЙЛАН

2023 он

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААС 2023 ОНД

ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 17 өдөр

Мандалговь

Нэг. Байгууллагын дотоод үйл ажиллагаа, удирдлага зохион

байгуулалт, хүний нөөцийн чиглэлээр

ХХААХҮЯамны сайдын 2023 оны А/18 дугаар тушаалын дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Мал аж ахуйн алба, Захиргаа аж ахуйн алба, Үйлдвэр, худалдаа үйлчилгээний алба, Хяналтын алба нийт 4 алба 20 орон тоотойгоор орон нутагт ХХААСалбарын бодлого шийдвэр, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХХААХҮсайд, аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ-95,0 %, Дундговь аймгийн Засаг дарга, ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээ-100 %, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр -100 %,ХХААГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт-99,3%, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-86,1%, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр-97,5 %, Байгууллагын стратеги төлөвлөгөө- 92,7% , Аймгийн стратеги төлөвлөгөө-83,3% бодлогын баримт бичгийн хэрэгжилт 94,2 хувьтай тус тус хэрэгжүүлэн ажилласан.

2023 онд аймгаас “Боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан 5 салбарын чиглэлээр 9 арга хэмжээг төлөвлөн нийт 4794 малчид, иргэдийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулахад төсөл хөтөлбөрийн байгууллага, сумдын засаг даргын тамгын газар, малчид иргэдтэй хамтран ажиллаж нийт 167,8 сая төгрөгийг зарцуулсан.

Хоёр Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр:

1. Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг тус байгууллагад хэрэгжүүлэх 2 зорилт 11 арга хэмжээг төлөвлөн газрын даргаар батлуулж хэрэгжилтийг 94,5 хувьтай хэрэгжүүлэн ажилласан.

ХХААСалбарын мэргэжилтэн боловсон хүчин 58 байхаас 33 албан хаагч ажиллаж, 2 суманд 2 мэргэжилтэн шинээр ажилд орж боловсон хүчний хангамж 56,8 хувьтай байна.

ХХААГазарт 13, сумдын ХААТасагт 15 албан хаагч, нийт 28 албан хаагч 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа нь хөдөө аж ахуйн салбарт одоо ажиллаж байгаа нийт албан хаагчийн 70 хувийг эзэлж байна.

Мал үржлийн албаны 1 сул орон тооны зарыг ТАСЗөвлөлд хуулийн дагуу хүргэсэн. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/18 тоот тушаалын 10 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны А/37 дугаар тогтоолын дагуу төрийн албаны нөөцөд бүртгэлтэй мал зүйч мэргэжилтэн Р.Галбадрахыг Мал үржлийн албаны сул орон тоонд мэргэжилтнээр томилон ажиллуулсан.

Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Хүний нөөц, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтнүүд хүүхэд асрах чөлөөтэй учир сул орон тоонд нөөцөд бүртгэлтэй 1 албан хаагч түр ажиллаж байна.

Сумдын хөдөө аж ахуйн тасагт нийт 17-н албан хаагч ажиллаж байна. Дутагдалтай байгаа албан хаагч 28, боловсон хүчний хангалт 37,7 хувьтай байгаа нь тулгамдаж буй асуудлын нэг болоод байна.

Тус байгууллагын албан хаагчдыг төрийн албанд ажилласан жилээр авч үзэхэд 0-5 хүртэл жил 5, 6-10 жил 6, 11-15 жил 4, 16-20 жил-2, 21-26 жил 2 буюу нийт албан хаагчдын 73,6 хувь нь 6 дээш жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид байна. Насны ангиллаар авч үзвэл 35 хүртэл насны залуучууд 3 буюу 15 хувь 35 дээш насны албан хаагчид 13 буюу 65 хувийг 45 дээш насны 4 албан хаагч 20 хувьд нь ажиллаж байна.

2. ХААИС-д мал зүйч мэргэжлээр 4 оюутан суралцаж аймгийн “Хүний нөөц”-ийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг дарга, ЗДТГазрын дарга, ХААИС-ийн МААБТСургуулийн төгсөгч оюутан М.Балжиннямтай 2021 оноос гурвалсан гэрээ байгуулж, 3-р курсын сургалтын төлбөрийн 50 хувь 1,761,000 төгрөг, 2022 онд 4-р курсын сургалтын төлбөр 3,560 000 төгрөг нийт 5 321 000 төгрөгийг төлж орон нутагтаа ажиллах боломжийг бүрдүүлж 2023 онд төгсөж Төрийн албаны шалгалтдаа тэнцэж орон нутагтаа ажиллах боломжийг бүрдүүлсэн.



3. Аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 01 өдрийн А/92 дугаар захирамж, ХХААГазрын даргын Б/10 дугаар тушаалаар төрийн захиргааны дэс түшмэлийн ангилалын 2 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон. Нийт 20 албан хаагч төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд хамрагдаж 2%-23% нэмэгдэл авч байна..

4. Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ шатлалын судалгааг гаргаж, газрын даргын 2023 оны А/01 дугаар тушаалаар баталж, мөрдөн хэрэгжүүлж байна. Холбогдох хууль, журмын дагуу албан хаагчдын цалинг Засгийн газрын 2023 оны 241 тогтоолын дагуу шинэчлэн тогтоож цалинг олгож ХНУМТ цахим системд төрийн албан хаагчдын мэдээллийг шинэчлэн холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаа Албан хаагчдын цалин дунджаар 30 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байна.

5.Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг сайжруулах удирдамжийг гаргаж, албан хаагчдын зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөний 2023 онд байгууллагын албан хаагчид богино болон дунд хугацааны 103 удаагийн сургалтад танхимаар-79 болон цахимаар-142 давхардсан тоогоор нийт 221-н албан хаагч сургалтад хамрагдаад байна. Байгууллагын дотоод сургалтыг төлөвлөгөөний дагуу 14-н албан хаагч, ажил албан тушаалын чиглэлээр буюу шинээр батлагдан мөрдөж буй хууль, тогтоол дүрэм журмын талаар давхардсан тоогоор 17 албан хаагч сургалт хийсэн. Нийт давхардсан тоогоор 28 албан хаагчийн сургалтад 215 ажилтан албан хаагч хамрагдсан.

6.“Хамтдаа суралцъя-Хамтдаа хөгжье” facebook групп нээж мал үржлийн албаны мэрэгжилтэн Э.Уугандорж хариуцан тогтмол ажиллуулж мэдээлэл солилцож байна. Нийт 65 мэдээллийг байршуулж түгээсэн.

7.Байгууллагын албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлын хүрээнд байгууллагын хэвлэмэл хуудсыг аймгийн архивын тасгаар хянуулан стандартын дагуу хэвлүүлэн ашиглаж байна.

8. Монгол бичгийг сурах, сургах түгээн дэлгэрүүлэх, сурч эзэмших, Монгол бичгийг сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэх “Үндэсний бичиг-III” хөтөлбөрийн хүрээнд Эрдмийн Далай цогцолбор сургуулийн сургагч багш Л.Уранбайгальтай гэрээ байгуулан 2020-2021 оны хичээлийн анхан шат, 2023 онд дунд шатны 24 цагийн модуль сургалтад хамрагдаж "БАТЛАМЖ"-аа гардан авсан. Нийт 17 албан хаагч хамрагдаж төгссөн. Монгол бичгийн сургалтын 1,020,000 төгрөгийн төлбөрийг байгууллагаас шийдвэрлэсэн. Цаг үеийн ажлын холбогдолтой 3 албан тоот монгол бичгээр туршилтын байдлаар сумдад хүргэсэн.



9.ХААИС-ийн Мал аж ахуй,биотехнологийн сургууль, Агроэкологийн сургууль, Мал эмнэлгийн сургууль, ХХААГазар хамтран ерөнхий боловсролын 5-н сургуулийн 9-12 ангийн 221 сурагчидтай уулзалт зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлүүдийн талаар мэдээлэл хийсэн. Мөн энэ үеэр аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг 12 дугаар ангийн нийт төгсөгчдөд танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан.

10. Уяхан замбуу тивийн наран Урлагийн их наадамд байгууллагаа төлөөлж 12 албан хаагч оролцсон.



11. Онцгой байдлын ерөнхий газраас Дундговь аймагт Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, Хүнс хөдөө аж ахуйн газрын "Хүнсээр хангах алба" мэргэжлийн анги 12 хүний бие бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах албаны бэлтгэл бэлэн байдалтай оролцсон.



12. Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын агентлагуудын дунд зохион байгуулагддаг спортын 5 төрөлт тэмцээнд амжилттай оролцож, НДХ, ХХААГ, Статистикийн хэлтсийн хамтарсан баг 2 хүрэл медалийн эзэд болсон.



13. Монгол улсад шинжлэх ухааны үндэслэлтэй мал үржлийн алба үүсч хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээнд зориулсан спортын 5 төрөлт тэмцээн 5 сарын 24-28-ний өдрүүдэд УБ хотод зохион байгуулагдлаа. Уг үйл ажиллагаа нь улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа бөгөөд ХХААХҮЯамны харъяа байгууллага, 21 аймаг, 9-н дүүргийн нийт 32 баг тамирчид оролцлоо. Үүнээс Дундговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын эмэгтэй баг тамирчид гар бөмбөгийн төрөлд хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан.

14. "Боловсролын чанар, хүртээмжийг дэмжих жил"-ийн ажлын хүрээнд аймгийн Засаг даргын ивээл дор зохион байгуулж буй Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн

үйлдвэрийн яам, ХААИС-ийн эрдэмтэн багш нар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо хамтран Хүнс, хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын мэдлэг, чадварыг дээшлүүлэх аймгийн “Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-ний сургалт, хэлэлцүүлгийг 03 сарын 28,29-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Тус сургалт, хэлэлцүүлэгт 15 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, малчид, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөл оролцож байгаа бөгөөд сургалт, хэлэлцүүлгийн үеэр ХААИС-ийн багш, судлаачид, орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийн инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэнг гаргасан.

15. Өөрийн хариуцсан ажил мэргэжлээрээ бусдыгаа манлайлан хошуучилж, Монгол Улсад санхүүгийн алба үүсэж хөгжсөний 112 жилийн ой, “Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны өдөр”-Дундговь аймгийн Санхүүгийн салбарын “Шилдэг нягтлан бодогч”-оор, нярав П.Мөнхсүх сангийн яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнагдсан.

Гурав . Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлаа

1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны 4 зорилт 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.
2. Байгууллагын албан хаагчдыг хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд Монгол Японы хамтарсан эмнэлэгт хамруулж 3,5 сая төгрөгийн төлбөрийг байгууллагаас 1,3 сая төгрөгний зардлыг албан хаагчдаас нийт 4,8 сая төгрөгөөр үзлэгт хамруулсан. Нийт албан хаагчид хамрагдсан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26,2 дахь заалтад тусгагдсаны дагуу тус байгууллагын нийт төсвийн 0,5 хувь буюу 3,5 сая төгрөгийг албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдах үйл ажиллагаанд зарцуулсан. 18-34 насны иргэдийн эрт илрүүлгийн үзлэгт 2 мэргэжилтэн хамрагдсан. Өнгөрсөн жил Улсын нэгдсэн 2-р эмнэлэгтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд албан хаагчдыг хамруулсны дагуу 5 албан хаагч хэвтэн эмчлүүлж, 4 албан хаагч гадуур эмчилгээ хийлгэж эрүүлжсэн байна.
3. ЖДҮХоршоо хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр хариуцсан мэргэжилтнүүдийг ажиллах нөхцлийг сайжруулж, сүүлийн үеийн DELL маркийн компьютер, мөн 2 албан хаагчийг принтерт болгох ажлыг төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 6,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Албан хаагчдын бичиг хэргийн зардалд нийт 1,2 төгрөг нийт 7,7 сая төгрөгийн төсөв зарцуулсан.
4. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдын 46 хүүхдэд 2238000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг гардуулж баярлуулав.
5. Сар шинийн баяр болон ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын өндөр настангуудад хүндэтгэл үзүүлж нийт 21 ахмад настанд 5342190 төгрөгний дэмжлэг үзүүлсэн.

6. Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд галлагаатай байшин, гэрт амьдардаг 10 албан хаагчид 2880000 төгрөгний дэмжлэгийг үзүүлсэн.
7. Байгууллагын эзэмшлийн 300 м² бүхий том хүлэмж, 40 м² жижиг хүлэмжийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тариалалт хийж, 0,6 тн ургац хураан авсан. Нийт 13 албан хаагч байгууллагын хашаанд 0,2 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж, 0,3 тн ургац хураан авч өөрсдийн өрхийн хэрэгцээгээ хангалаа.

Дөрөв. Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр зохион байгуулсан ажил

1. Авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 5 зорилт бүхий 16 заалт бүхийн төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулж жилийн эцсийн хэрэгжилт 100 % хэрэгжсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “**ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА**” аянд нэгдэж, иргэд, олон нийт албан хаагчид, хүүхэд залуучуудад авилгыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг тайлбарлан таниулах, авлигын эсрэг үйлсэд дуу хоолойгоо нэгтгэн, олон нийтийн дуу хоолойг сонсох, хүсэл зоригоо илэрхийлэх боломж нөхцөлийг бүрдүүлж, иргэн аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллаа. Авлигатай тэмцэх газрын сайтад байршуулсан байсан тв шторк, видео график, зурагт хуудас нийт 12 төрлийн 12 шторк, мэдээллийг Дундговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын пейж хуудсанд байршуулан сурталчилж, уг мэдээллийг 223 иргэнд хүргэж ажилласан. Мөн “Шударга ёс хөгжил дэвшилд хамтдаа аян” уриалгад нэгдэж, 110 дугаарыг сурталчлах нэгдье зургийн хүрээг өөрийн өөрсдийн хувийн цахим хаягаар байгууллагын 20 албан хаагч сурталчилж, уг мэдээллийг хүргэж ажилласан.

2.Авилга, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх, 110 дугаарын талаарх сурталчилгааны хуудсыг тус газрын газрын 2 мэдээллийн самбарт байршуулж, иргэдэд сурталчилсан.

3.Аймгийн худалдааны төвүүд Номгон супермаркет, Хайрхан супермаркет, Хайрхан сэлбэгийн дэлгүүр, Дэлгэрэх судал супермаркет, Жавхлан супермаркет, Цоглог супермаркет,Бүрд ресторан, Хүнсний зах, жимс ногооны дэлгүүр нийт 20 цэгт авлигын эсрэг “НЭГДЬЕ” арга хэмжээний сурталчилгааны постеруудыг байршуулж, авлигын эсрэг арга хэмжээг сурталчилсан гарын авлага материалыг Хүнс, хоол, худалдаа үйлчилгээний газар болон жижиг дунд үйлдвэр эрхлэгч 50 ААНБ, иргэдэд мэдээлэл өгч, ажлын байрны мэдээллийн самбарт мэдээллийг байршуулан үйлчлүүлэгчид мэдээлэл хүргэн ажилласан.

4.ЭБАТ хариуцсан мэргэжилтнүүд хамтран сурталчилгааны 2 самбарт “Авлигын эсрэг нэгдье” баннер байршуулсан.

5. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Архивын тасаг, Хүний эрхийн Үндэсний комиссын Дундговь аймаг дахь салбар хамтран Авлигын эсрэг болон Хүний эрхийн олон улсын өдөр, Архивчдын өдрүүдийг тохиолдуулан “Мэдлэг – Ур чадвар” уралдааныг 2023 оны 11 сарын 27 өдөр зохион байгуулсан.


Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёл урлагийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Зооноз өвчин судлалын албаны хамтарсан баг амжилттай оролцож Дэд байрт шалгарсан. Ур чадварын уралдаанд тус байгууллагын бичиг хариуцсан мэргэжилтэн Криллээс-Монгол бичиг рүү хөрвүүлэх тоот төлөвлөх, архивын баримт бичиг үдэх уралдаанд багаа төлөөлөн оролцож тус тус 2-р байр эзэлсэн.

ХОЁР. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Бодлого, зорилтот арга хэмжээний талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан гэрээ газрын даргатай байгуулсан гэрээ, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад аймаг, сум орон нутгийн болон чиг үүргийн бусад байгууллагуудтай хамтран ажилласан

2023 оны мал өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал цаг агаарын олон удаагийн шороон шуурганд мал ядарч сулдах, доройтох, эх мал, төл, том малын зүй бусын хорогдол ихээр гарсан. Том малын зүй бусын хорогдлыг сүүлийн 3-н жилээр харьцуулж харахад 2021 онд нийт малын 0,75 хувь нь хорогдсон бол 2023 онд нийт малын 0,56 хувь буюу 0,19 хувиар буурсан байна.



Малын зүй бус хорогдлын мэдээ, мал төллөлт, төл бойжилтын мэдээг 7 хоног бүр малын нэгдсэн системийн программд шивсэн.

Оны эхний хээлтэгч 1,5 сая малаас 1,1 сая хээлтэгч төллөж төл бойжилт 97,2 хувьтай буюу 1,08 сая төл бойжсон.

2023 оны хавар аймгийн баруун тал, урд талын сумдуудад зуншлага тааруу байснаас малчдын отор нүүдэл ихэсч гадны аймаг болох Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Булган, Улаанбаатар зэрэг 9 аймаг нийслэлд 157 өрхийн 94808 толгой мал Өөрийн аймаг дотор 372 өрхийн 236247 толгой мал оторлож байна. Мөн гадны Өвархангай, Өмнөговь, Төв, Дорноговь зэрэг аймгуудын 158 өрхийн 127436 толгой мал орон нутагт оторлож хур тунадас орсноор нутаг нутагруугаа буцсан. Өмнөговь аймгийн малчид отор нүүдлээр орж ирэх төлөвтэй байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 12-р сарын 22-ны өдрийн А/529 захирамжаар аюулгүй нөөцийн 249тн өвсийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр 9 суманд хуваарилан олгож мөн хямдралтай үнээр 60тн тэжээлийг малчдад тараасан.

Аймгийн Засаг даргын 2023 оны 01-р сарын 16-ны өдрийн А/25 захирамжаар Улсын нөөцийн 570,2 тн тэжээл, 366,9тн өвсийг 50 хувийн хямдралтай үнээр 15 суманд тараасан.

Нэг.Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл зохион байгуулалт

Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 07 сарын 31 -ны өдрийн А/459 тоот захирамжаар өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж аймгийн мал аж ахуйн салбарын 2023-2024 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалтыг 88,2 хувьтай хангаад байна.

Аймгийн хэмжээнд 15 сумын 68 багийн нутагт 7682 малчин өрхийн 3,7 сая толгой мал, хонин толгойд шилжүүлснээр 5,1 сая толгой мал өвөлжиж байна.

Бэлчээрийн талбайн хэмжээ 6,5 сая га, бөгөөд энэ оны бэлчээрийн дундаж ургац 3,1 цн, өвөлжих малын тоонд харьцуулснаар 2,1 сая га бэлчээрт мал өвөлжиж хаваржихад хэвийн, бэлчээрийн хүрэлцээ хангамж 33 хувьтай байна.

Гадны аймаг, сумдын нутагт отроор 69 өрхийн 48551 мал, өөрийн аймгийн өөр сумын нутагт 66 өрхийн 33868 мал, Тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 8 өрхийн 9593 мал, нийт 143 өрхийн 92012 тоо толгой мал отроор буюу нийт малчин өрхийн 0,01 хувь, нийт малын 2,5 хувь нь отроор өвөлжиж хаваржих төлөвтэй байна.

Байран тэжээлд орох 3100 мал, хонин толгойд шилжүүлснээр 21700 толгой мал, нэмэгдэл тэжээлд оруулах 136332 толгой мал, хонин толгойд шилжүүлснээр 128649 тоо толгой малыг тэжээлд оруулах урьдчилсан тооцоо гарсан.

Малчдын өөрсдийн бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлт, өвс 2304,8 тн, үйлдвэрийн тэжээл 1536,6 тн, гар тэжээл 1882,1 тн, давс хужир шүү 2681,6 тн бэлтгэж, бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн нөөцийг 66 хувьтай хангасан.

Аймаг сумдын Засаг даргын аюулгүй нөөц бүрдүүлэлтийг Засгийн газрын 279 дугаар тогтоолын дагуу сум бүр өвс, тэжээлээ нөөцийг бүрдүүлж аймгийн хэмжээнд өвс 689,2 тн, тэжээл 289,8 тн бэлтгэвэл зохих аюулгүй нөөцийг өвс, тэжээлийг 93,4 хувьтай бүрдүүлсэн.

Бэлчээрийн менежментийн чиглэлээр

Малчдын 1,134,0 сая төгрөгийн хөрөнгөөр Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 36 малчин өрх өвөлжөө, хаваржаагаа түшиглэн нийт 567 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалаад байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 20, 0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг сумын Баянхошуу, Хулд сумын Дал, Сайхан-Овоо сумын Дэлгэрэхийн булгуудын эхийг хашиж хамгаалсан.

Бэлчээр усжуулалтын чиглэлээр

Улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, малчдын хувь хөрөнгө 1396,1 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Дэлгэрхангай, Луус, Өлзийт сумдад инженерийн хийцтэй 18 худаг, Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад 30 цооног, тус тус гаргасан.

Мөн Орон нутгийн хөгжлийн сан, малчдын хувь хөрөнгө 205,7 сая төгрөгний санхүүжилтээр Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан сумдад 44 энгийн уурхайн худаг сэргээн засварласнаар нийтдээ 72,0 мянган га бэлчээрийн талбайг усжуулж өмнөх оноос 0,7 хувиар бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлсэн.

Ургамал хамгааллын чиглэлээр

Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тогтоол” Бэлчээр хамгаалах өдрийг тохиолдуулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/218, А/587 дугаар захирамжуудын дагуу Улсын төсвийн 167,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдад 10,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар, мөн энгийн механик аргаар 30 мянган га бэлчээрийн талбайд байгальд халгүй аргаар тэмцснээр нийт 40,0 мянган га талбайд тэмцсэн.

Малын тэжээлийн хэрэгцээ, хангамж

Дэлхийн зөн олон улсын байгууллага, малчдын хувийн хөрөнгө 101,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянжаргалан, Гурвансайхан, Луус, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр сумдын малчид, Эрдэнэдалай сумын малчдын бүлэг нийт 15,9 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 15,8 тн ургац хураан авсан.

Хоёр.Эрчимжсэн мал аж ахуйн мэдээлэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тоо, хэмжээ

Аймгийн хэмжээнд эрчимсэн аж ахуйн чиглэлээр Жаргалант сор ХХК нь тахианы аж ахуй 2021 оноос үйл ажиллагаагаа явуулж өдөрт 6000-7000 өндөг, жилд дундажаар 70,000 шинэ өндгөөр аймгийнхаа хэрэглэгчдийг хангаж байна.

2022 оноос Үржих эрдэнэ дэвжих ХХК нь гахайн аж ахуй эрхэлж жилд 2,1 тн мах худалдан борлуулж байна.

Түргэн өсөлттэй өндөр ашиг шимтэй суффолк үүлдрийн хуцны үрээр нутгийн монгол эм хонинд зохиомол хээлтүүлэг хийж, 350 төл хүлээн авч, 9 сартай хурга 45-50 кг амьдын жинтэй F-1 хурганы 1,3 тн махыг зах зээлд борлуулсан.

Гурав.Монгол малчин үндэсний хөтөлбөрийн биелэлт

Монгол малчин үндэсний хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх 37 заалт бүхий төлөвлөгөөг батлуулан 84,1 хувьтай хэрэгжилтийг хангаж ажилласан.

Мал аж ахуйн уламжлалт мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран адуу, тэмээ, хонины болон айрагны өв соёлын талаарх 5-н төрлийн нэвтрүүлэгт бэлтгэж олон нийтэд түгээн дэлгэрүүлсэн.

2023 оны 2, 5 саруудад Аймгийн Засаг даргын 15-н сумдын малчид, иргэдтэйгээ уулзах уулзалтын ажлын хэсэгт ажиллаж 2000 иргэд, малчдад мал аж ахуйн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн.

НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллагаас Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумдын цөөн малтай 30-н малчин өрхөд мал аж ахуйн талаарх сургалтыг хийж тусламжийн эд зүйлсийг хүлээлгэн өгсөн.

Мал аж ахуйн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг 15 сумын 545 малчидтай уулзаж хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулсан.

Мал аж ахуйн сэргэлт залуу малчдын үндэсний чуулганд 15 сумын 35 залуу малчид оролцсон.

10 сарын 22 нд “Мал аж ахуйн салбарын эмэгтэйчүүд” 400 малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулсан.

Өлзийт, Говь-Угтаал, Луус сумдын 700 малчдын зөвлөгөөнд оролцож мал аж ахуйн чиглэл, бэлчээр, тэжээлийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн. энэ онд 6-н арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор нийтдээ 4010 малчинд мэдээлэл хүргэж ажилласан.

БАРИМТЖУУЛАЛТ

ХОЁР. МАЛ ҮРЖИЛ, БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Малд үзлэг ангилалт хийсэн талаар

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 сарын А/473 тоот тушаалын дагуу баталгаажсан үүлдэр омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, ялган тэмдэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын 2023 оны 09 сарын 19-ны өдрийн А/531 дүгээр захирамжийн дагуу Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжүүд, сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд хамтран 15 сумын хуц 12935, ухна 10543, нийт 23478 бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт явуулж анги чанарыг тогтоолоо.

Аймгийн хэмжээнд 23478 бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийсэн. Үүнд 12935 хуц ангилснаас цөм сүргийн ангид 6221 хуц буюу нийт хуцны 48,1 хувь, үржлийн ангид 4281 буюу 33,1 хувь, хэрэгцээний ангид 2289 буюу нийт сүргийн 17,7 хувь нь, 10543 ухна ангилснаас цөм сүргийн ангид 5092 буюу нийт сүргийн 48,3 хувь, үржлийн ангид 3605 буюу нийт сүргийн 34,2 хувь, хэрэгцээний ангид 1950 буюу нийт сүргийн 18,5 хувь тус тус хамрагдсан. Бог малын хээлтүүлэгчийг нийтэд нь авч үзвэл цөм сүргийн ангид 11510 буюу нийт сүргийн 48,2 хувь, үржлийн сүрэгт 7666 буюу нийт сүргийн 33,7 хувь нь, хэрэгцээний сүрэгт 4302 буюу нийт сүргийн 18,1 хувийг тус тус эзлэж байна.

Хэмжилтэд орсон хуцны дундаж үзүүлэлтүүд болох сэрвээний өндөр 72 см, хондлойн өндөр 73 см, биеийн ташуу урт 83 см, намрын амьдын жингийн дундаж 1-2 нас 53 кг, 3-аас дээш нас нь 71,4 кг амьдын жинтэй байна.

Хэмжилтэд орсон ухнын дундаж үзүүлэлт болох сэрвээний өндөр 67 см, хондлойн өндөр 68 см, биеийн ташуу урт 76 см амьдын жингийн дундаж 1-2 нас 48 кг, 3 дээш нас 55 кг дундаж үзүүлэлтүүдтэй байгаа нь монгол үүлдрийн хонь, ямааны стандарт хэмжээтэй дүйж байна.

Сайнцагаан сумын Засаг даргын 06 сарын 12-ний А/164 тоот захирамжаар Сайнцагаан омгийн 4100 хонинд хавар, намрын үзлэг ангилалт хийсэн. Ангилалтад хамрагдсан хуцны дундаж үзүүлэлт болох сэрвээний өндөр 74см, хондлойн өндөр 73см, биеийн ташуу урт 83 см, цээжний гүн 33 см, цээжний өргөн 17 см, цээжний бүслүүр 78 см, шилбэний бүслүүр 8 намрын амьдын жин 69 кг, эм хонины дундаж үзүүлэлтүүд болох сэрвээний өндөр 73 см, хондлойн өндөр 72см, биеийн ташуу урт 78 см, цээжний гүн 28см, цээжний өргөн 14,5см, шилбэний бүслүүр 8, намрын амьдын жин 62 кг тус тус байна. Дээрхи үзүүлэлтүүд нь “Сайнцагаан” омгийн хонины стандарт хэмжээтэй дүйж байна. Сайнцагаан омгийн хонинд жил бүр үзлэг ангилалт хийснээр малын чанар сайжрах малчдын малын чанар сайжарч ангилалтын үр дүн сайн цөм сүргийн ангийн малын тоо жил ирэх тусам өсөж байна.

2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө

Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй биотехнологийн сургуулийн багш нартай хамтран Аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны /2023-2033/

он хүртэл хэрэгжүүлэх 11 зорилт, 7-н бүлэг арга хэмжээ бүхий стратеги төлөвлөгөөг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 28 дугаар тогтоолоор төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулсан.

3.Ялган төвлөрүүлсэн хээлтүүлэгч малын тоо

Бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус үед нь ялган суурилж хуц-5815, ухна - 5972 нийт 11787 хээлтүүлэгч малыг ялган суурилсан. Нийт ялгавал зохих хээлтүүлэгч малын 50,2 хувийг ялган суурилсан.

4. Биотехнологийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх

Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй биотехнологийн сургуулийн зоо инженер технологийн 4 дүгээр курсын оюутнуудтай хамтран Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол эм хонинд, өндөр ашиг шимт суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс тус тус үр авч 500 эм хонинд зохиомол хээлтүүлэг хийсэн

Битүү хөнгөлгөөний аргаар Сайнцагаан, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Адаацаг сумдад хурга 250, бяруу 20, нийт 270 малыг хөнгөлж энэ онд 570 малд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажил хийгдээд байна.

Хөдөө аж ахуйн дэвшилтэт технологи, институт байгууллага,Өлзийт сумын ЗДТГазартай хамтран Дэл уулын улаан ямааны ноолуурын судалгааны ажлыг Төрийн соёрхолт, ямаа судлаач, доктор Б.Мандахаар ахлуулсан ажлын хэсэг 25 өрхийн 1-4 -ны насны 5000 ямаанаас ноолуурын хэмжээ болон дээж, хяналтын самналт, намрын үзлэг ангилалт, амьдын жингийн дундажийг тооцсон. Мөн малчдад ноолуурын ямаа, сүргийн зохистой харьцаа, хээлтүүлэгч хэрхэн зөв сонгон тавих, ноолуурын нарийн микрон болон ямааны аж ахуйн талаар мэдээлэл өгч ажилласан. 2023 оны 07 сард улаан ямааны генетик нөөцийн судлуулахаар 4-н өрхийн 30 ямааны чихнээс генетикийн судалгааны дээж авч мал аж ахуй хүрээлэнд хүргүүлсэн.

5.Хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Азийн хөгжлийн банкны “Тэжээлийн тогтвортой менежмент төсөл”-ийн газарт ХХААГ-аас санаачлан газар тариалан эрхлэх тоног төхөөрөмжийг нийлүүлэх хүсэлт хүргүүлсэний дагуу 80,0 сая төгрөгний өртөг бүхий 60 морины хүчтэй трактор 4 дагалдах хэрэгслийн хамт олгож дэмжлэг үзүүлж хамтран ажиллаа. Газар тариалан эрхлэгч 10 өрхийн 6 га талбайг хагалж хөрс боловсруулсан.

Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын Гамшигт тэсвэртэй Орон нутаг төслийн 79,9 санхүүжилтээр Эрдэнэдалай сумын Далайн Шим малчдын бүлэгт тэжээлийн ургамал тариалахад усалгааны төхөөрөмж, хашаа, трактор дагалдах

хэрэгсэл болон холбогдох бусад тоног төхөөрөмжийг олгож 2га талбайд туршилтаар ногоон тэжээл тариалж ургуулсан.

6.Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан түүний нэгдсэн түүний дэд сангуудын ашиглалт, нэвтрүүлэлтийн талаар

Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 8900 малчин, мал бүхий өрхийн малын мэдээллийг шинэчлэн засаж оруулсан. Мөн мал төллөлт, төл бойжилтын мэдээ, том малын зүй бусын хорогдлыг сумдууд 7 хоног бүр шивж оруулж ажилласан.

Энэ оны бойжсон төл болох 1,0 сая төл малыг мэдээллийг шивж оруулсан.

Бог малын хээлтүүлэгч малд үзлэг ангилалтанд хийхээс гадна хуц 6202, ухна 4299. Бух 119 бүгд 10620 хээлтүүлэгчийг ээмэглэж малын бүртгэлийн нэгдсэн системд бүртгэж байна.

7.Мал үржлийн албаны 2023 оны ололт, амжилт, үр дүн

Монгол улсад шинжлэх ухааны үндэслэлтэй мал үржлийн алба үүсэн байгуулагдсны 100 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэхдээ холбогдуулан шинэлэг ажлуудыг орон нутгийн малчид, иргэд, мэргэжилтнүүдийн хандиваар зохион байгуулсан нь энэ жилийн нэг том ажил байсан бөгөөд ахмад мэргэжилтнүүдийнхээ арга туршлагаас суралцсан ажлын нэг болсон.

Аймгийн хэмжээний богийн хээлтүүлэгчийг 100 хувь үзлэг ангилалтанд хамруулсан нь малчид, бог малын хээлтүүлэгчээ ялган суурилдаг, мал үржлийн чиглэлийн үйл ажиллагааг дэмждэг малдаа биотехнологийн дэвшилт аргыг туршиж үзэж байгаа нь бидний ажлын үнэлэмж өсөж байгаагийн илрэл юм.

Мал аж ахуйн салбар болон аймгийнхаа 3 омгийн малыг сурталчлан таниулах зорилгоор 3-5 төрлийн хөрөг нэвтрүүлэг бэлтгүүлж олон нийтийн тедевизээр цацаж түгээсэн нь мал аж ахуйн салбараа сурталчилан таниулсан ажлын ахиц гарсан юм.

Тэмээний баяр, адуу, айрагны баяр, мал аж ахуйн эвент арга хэмжээг жил бүр түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулж хэвшсэн ба жил ирэх тусам сонирхож буй малчид, иргэдийн тоо нэмэгдэж байна.

ГУРАВ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

1. Мал үржлийн албаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай

Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэй мал үржлийн албан үүсэн байгуулагдсан түүхэн 100 жилийн ойг 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн. Уг арга хэмжээнд үе, үеийн түүхэн гавьяа байгуулж ажиллаж байсан олон мал зүйч, зоо техникчид цугласан.

Энэ онд мөн Эрдэнэдалай сумын ахмад мал зүйч Ж.Очир монгол улсын гавьяат мал зүйч хэмээх эрхэм алдрыг хүртэж салбартаа болон аймгийнхаа хэмжээнд

гавьяатын тоог нэгээр нэмсэн түүхэн амжилттай. Мөн Зөвлөгөөний үеэр Хулд сум мөнгөн буйлаар шагналуулсан.

Мал зүйчдийн алдар, Бид Дундговийн мал зүйч хэмээх мэргэжлийн үг хэллэгээр агуулсан дуу, магтаалтай болсон.

Мал үржлийн албаны ЛОГО гаргаж, энгэрийн тэмдэг болон гарын бэлгүүдийг бэлтгэн зөвлөгөөнд оролцсон төлөөлөгч нарт хүргэсэн.

Дундговь аймгийн Мал зүйчдийн номын эмхэтгэл гаргасан.

Хулд сумын 100 жилийн ойд зориулан ЗДТГ-тай хамтран Олдохын хүрэн бор омгийн тэмээний номыг мөн гаргасан.

Ойн арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн хандивлагч нарт “Талархал” гардуулсан.

2. Тэмээний эвэнт арга хэмжээ

АЗДТГ, ХХААГ, Хулд сумын ЗДТГ хамтран 2023 оны 01 дүгээр сарын 26-нд “Тэмээний өв соёл эвэнт” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж шилмэл тормон тэмээ, тайлган тэмээ, ойрын зайны буухиа уралдаан, сайхан буур, ингэ, ганган хос, сүүтэй ингэ, буйл зорох, бурантаг томох, тэмээний сүү, ноосон бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, зохион байгуулалттай нэг сум шалгаруулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Үйл ажиллагаанд Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо, Манлай сумд, Дэлгэрхангай, Өлзийт сумдаас уг арга хэмжээнд оролцсон.

3. "Адуучны өв соёлын баяр" эвэнт арга хэмжээ

“Адуучны өв соёлын баяр” эвэнт арга хэмжээг Адаацаг сумын “Сүм хөх бүрд” эртний түүх, соёлын дурсгалт газар 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэхүү газар нутаг нь эртнээс Өгөдэй хааны намаржаа хэмээн түүх, сударт тэмдэглэгдэж Адуун сүргийн гол цөм цэг болдгоороо онцлог юм.

“Адуучны өв соёлын баяр”-ын Адуучин тэмцээнд Өвөрхангай, Говьсүмбэр, Төв, Дундговь 4 аймгийн 72 адуучин залуус оролцож 700 гаруй хүн оролцож үзэж сонирхлоо. Мөн сайхан хөхүүр, хуруу наадгай, дэмбээ, сайхан айрагтай өрх, хамгийн сайн айраг уух вэ, хос морьтон зэрэг олон тэмцээн зохион байгуулагдсан.

ГУРАВ.САЛБАРЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Хяналтын алба нь 2023 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго, 8 зорилт, 17 арга хэмжээг төлөвлөн Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Малын генетик нөөцийн тухай, Ургамал хамгааллын тухай, Улсын нөөцийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиуд, Засгийн газрын хяналт шалгалтын төлөвлөгөө, Хүнс хөдөө аж ахуйн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго, зорилтыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн хүнсний аюулгүй байдлыг

хангуулах, иргэдэд аюулгүй хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, зорилтын хүрээнд хийгдэх ажлуудыг алба, улсын байцаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллалаа.

1. Төлөвлөгөөт хяналт шалгалтын чиглэлээр хийсэн ажлаас

Хүнсний чанар стандартын хяналтаар:

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 06 дугаар сарын 06-ны 08-00-02/06, дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 хяналтын чиглэлээр 60 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 6 объектын үйл ажиллагаа зогссон. Шалгалтыг хүнсний үйлдвэр 4, худалдааны 28, хоол үйлдвэрлэлийн 22, нийт 54 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн.

Хяналт шалгалтаар эрсдэлийг үнэлэхэд 8 объект дунд, 46 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, давхардсан тоогоор нийт 461 дутагдал илрүүлж, хяналт шалгалтын явцад 23,2% буюу 107 дутагдлыг тухайн объект дээр нь арилгуулсан.

Бусад дутагдлуудыг арилгуулахаар 354 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгсөн. Албан шаардлагын хэрэгжилт 94,6%-тай байна. Хууль тогтоомжийн хэрэгжилт 80,5%, эрсдэл үүсэх магадлал 19,4%-тай.

Хяналт шалгалтын явцад стандарт дүрэм журам мөрдөж ажиллаагүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөөгүй нэг иргэнд хялбаршуулсан журмаар Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 5.3 дахь заалтын дагуу 300000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаа.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан 46 объект буюу 85,1% нь эрсдэл буурсан байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар эрсдэл үүсэх магадлал 11,75%, Хууль тогтоомжийн хэрэгжилт 95,3% байна.

Мал үржүүлгийн технологийн хяналтаар:

Мал үржлийн хяналтын чиглэлээр их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 15 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж 14 их, 1 дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Гүйцэтгэлийн хяналтад 100% хамруулж 9 их, 4 дунд, 2 бага эрсдэлтэй болсон байна. Эрсдэл үүсэх магадлал дунджаар 17% буурсан, хууль тогтоомжийн хэрэгжилт 18%-иар нэмэгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 198 зөрчил илэрснээс 148 зөрчлийг бүрэн арилгуулж, албан шаардлагын хэрэгжилт 75%-тай хэрэгжилтийг хангасан байна.

2.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын чиглэлээр хийсэн ажлаас:

1. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2023 оны 08 дугаар сарын 30-ны 08-00-02/18 дугаартай удирдамжийн дагуу 20 хүнсний дэлгүүр, 8 минимаркет, 4 мухлаг буюу нийт 31 газрын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтын явцад давхардсан тоогоор нийт 57 дутагдал илрүүлж, хяналт шалгалтын явцад 60% буюу 34 дутагдлыг тухайн объек дээр нь арилгуулж, 23 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг 3 газарт өгсөн.

Шалгалтын явцад хүнсний дэлгүүрийн худалдааны лангуу дээрээс бүтээгдэхүүний хадгалах болон хэрэглэх хугацаатай холбоотой зөрчил дутагдал илрээгүй боловч агуулахад дотоод хяналтаараа илрүүлсэн гэх боловч буцаан татан авалтын хаяггүй лангуунд өрсөн, хадгалалтын хугацаа дууссан, сав баглаа боодлын битүүмжлэл алдагдсан 15 нэр төрлийн 217 ширхэг 417600 төгрөгийн / чихэр, жүүс, энергийн ундаа, набор, аарц, шар айраг, печень, гурилан бүтээгдэхүүн, үрэл, кит кат гэх мэт/ хүнсний барааг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, дотоод хяналтаар нь устгуулсан.

Шалгалтаар дагалдах шинжилгээний бичиггүй 2 төрлийн /молоко/ 2 ширхэг бүтээгдэхүүнээс дээж авч, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээний хариу стандартын шаардлага хангасан байна.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 6 газарт хийсэн. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар албан шаардлагын хэрэгжилт 91%-тай байна.

Хяналт шалгалтын явцад эрсдэлийг бууруулах, зөрчил дутагдлыг таслан зогсоох арга хэмжээ авч, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон дотоод хяналтын журмын дагуу хэрхэн хяналт хийх, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, аюулгүй байдал, шошгын талаарх мэдээлэл, хадгалах болон хэрэглэж дуусах хугацааны тэмдэглэгээ, тэдгээрийг зөв унших, ойлгох талаар 31 газрын 93 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хүнсний сүлжээний хадгалах, худалдах үе шатанд дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаагүй 18 газарт дотоод хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлж, ажиллах талаар улсын байцаагчийн зөвлөмж өгч ажиллаа.

2. Тайлант хугацаанд 1 иргэнээс ирсэн гомдол мэдээллийн дагуу 1 аж ахуй нэгжид төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 15 дутагдал илэрч, улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч дутагдлыг арилгуулсан. Шалгалтын үр дүнд зөрчил дутагдал арилгуулалт 80%, хууль сахин мөрдөлтийн хэрэгжилт 85%-тай болсон. Хяналт шалгалтаар хийгдсэн ажил, авсан арга хэмжээ, үр дүнг гомдол гаргагчид албан бичгээр өгч, танилцуулж ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%.

Үр дүн: Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар зөрчил дутагдал арилгуулалт 90%, хууль сахин мөрдөлтийн хэрэгжилт 85%-тай болсон.

3. Онцгой байдлын газраас ирүүлсэн хүсэлтээр Улсын нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу өвс, тэжээлийн чанар аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжаар 3 объектод шалгалт явуулахад бүтээгдэхүүн хадгалах агуулах нь стандартын шаардлага хангаж буй эсэхэд үнэлэлт дүгнэлтийг өгч ажилласан. Шалгалтаар ажилчдын ажлын байр шаардлага хангахгүй, агуулахын дээврээр ус чийг орохоор цоорч эвдрэл үүссэн, бүтээгдэхүүнийг ачиж буулгах зориулалтын тавцангүй, хаалганы доод хэсгээр мэрэгч хортон шавж нэвтэрч орж гарахаар зай завсартай зэрэг 10 зөрчил дутагдал илрүүлж, арилгуулах зорилгоор 4 заалт бүхий улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. Стандарт хангалтын байдал дунджаар 82,5%-тай, зөрчил арилгалт 75%-тай.

4. Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготной энгийн механик аргаар тэмцэж ажлыг зохион байгуулж буй 5 сумдын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжаар хяналтыг хийж явцын шатандаа байна.

3.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн талаар

Хүнсний чанар стандартын хяналтаар: .

Нийтийг хамарсан баяр ёслол, Хүүхдийн зуслан, гадаад орны болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалт бүхий этгээд, зочин төлөөлөгчдийн айлчлалын үед хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар худалдааны 113, хоол үйлдвэрлэлийн 56, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр 5, нийт 159 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар бүтээгдэхүүний хадгалах горим, бүртгэл хөтөлгөөтэй холбоотой нийт 382 дутагдал илрүүлж, 97,8%-ийг тухайн газар дээр нь арилгуулж, 6 аж ахуй нэгжид 56 заалттай улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч ажилласан. Албан шаардлагын хэрэгжилт 89%.

Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, хүнсний нэмэлт, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа зэрэг 3 сэдвээр зөвлөмж гарын авлага хийж, 7 сумын аж ахуй нэгж, иргэдэд 80 ширхгийг түгээж, 54 газрын 104 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол” сэдвээр малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцогч 149 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан.

Үр дүн: Хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдвар гараагүй байна.

Мал үржүүлгийн технологийн хяналтаар:

Мал үржлийн хяналтын чиглэлээр Өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалд болон микробиологийн аргаар бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх үйл ажиллагааг шалгах 2 урьдчилан сэргийлэхийн удирдамжийн хүрээнд 30 объектыг хамруулсан.

Шалгалтаар 8 төрлийн 17 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 6-г арилгуулж, үлдсэн дутагдлыг арилгуулахаар байгууллагын даргын албан бичгээр 1, улсын байцаагчийн 1 нийт 2 зөвлөмжийг 16 объектод хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан.

Хяналт шалгалтын явцад “Малын арчилгаа маллагаа, тэжээлийн хэрэгцээ шаардлагыг тооцох тухай”, “Микробиологийн болон энгийн механик аргаар оготной тэмцэх, үр дүнг тооцох, аюулгүй ажиллагааны тухай” 2 төрлийн сэдвээр 8 суманд 45 албан хаагчид, 615 малчдад мэдээ мэдээллийг өгч сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулсан. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 88,2 хувьтай хангагдсан байна.

Шалгалтыг товлосон хугацаанд нь хийж гүйцэтгэн холбогдох дээд шатанд мэдээллийг хүргүүлэн ажилласан

4.Баталгаажуулах үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/28 дугаартай удирдамжийн хүрээнд Монгол

Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5².1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15¹.3 дахь хэсэг, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд болон холбогдох стандарт, журам, дүрмийн хэрэгжилтийн байдалд 8 аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, бүртгэл хөтөлгөөтэй холбоотой 6 дутагдлыг тухайн газар дээр нь арилгуулж, **ажлын байрны улсын байцаагчийн 8** дүгнэлт гаргаж ажилласан.

Үр дүн: Шаардлага хангаагүй аж ахуй нэгж гараагүй байна.

Өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангалтад хяналт хийсэн чиглэлээр:

ХХААХҮЯ-наас ирүүлсэн удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээний 15 суманд МАА-н өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд хяналт шалгалтыг хийж удаашралтай болон хийж гүйцэтгээгүй 5 төрлийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймаг, сумдын удирдлагуудад улсын байцаагчийн хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна. Мөн сумдын тасгийн мэргэжилтэн нарт малын бэлчээр сонгох, малд тэжээлийн хэрэгцээ шаардлагыг тооцоолох арга аргачлалын тухай сургалтын хичээл бэлтгэн өгч 3 сумын 615 малчид, иргэдэд мэдээллийг хүргэн ажилласан. Хяналт шалгалтын дүн танилцуулгыг гаргаж холбогдох дээд шатны улсын байцаагчид хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Үр дүн: Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 88,2 хувьтай хангагдсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 7 сумын 10 мян.га бэлчээрийн талбайд бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцсэн ажилд явцын хяналтыг хийж нийт 12 зөрчил дутагдал илрүүлж газар дээр нь 6 зөрчлийг арилгуулж, үлдсэн 6 дутагдлыг арилгуулахаар 1 сумын удирдлагад албан бичгээр үүрэг чиглэл өгч ажлыг сайжруулан гүйцэтгүүлсэн. Хяналт шалгалтын явцад УХЭШХүрээлэнгийн мэрэгч судлаачтай хамтран холбогдох 7 сумдын багийн Засаг дарга нар мэргэжилтэн нийт 45 иргэнд технологийн заавар зөвлөгөө өгч алдаа дутагдлыг газар дээр нь арилгуулсан. Ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгч, хяналт шалгалтын дүн танилцуулгыг холбогдох дээд шатны байцаагчид хугацаанд нь хүргүүлэн ажилласан. **Үр дүн:** Микробиологийн аргаар тэмцсэн ажлын хээрийн техникийн үр дүн 87 хувьтай үнэлэгдсэн.

Аймгийн хэмжээнд нийт 7 сумын 10,0 мянган га талбайд микробиологийн аргаар, 5 суманд 30 мянган га талбайд энгийн механик аргаар, нийт 40 мянган.га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх үйл ажиллагаанд тавих хяналтын ажлын явц 85%тай үргэлжилж байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлсэн байдалд хяналт хийсэн чиглэлээр:

Улсын төсөв, орон нутгийн төсвийн 1190,4 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдад инженерийн хийцтэй 5 худаг

гаргаж хүлээлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт хяналт тавин ажиллаж орон нутагт хүлээлгэн өгөхөөр боллоо.

Малын тоог чанарт шилжүүлж, биотехнологийн ололтыг 700 малд шинээр нэвтрүүлэхэд хяналт хийсэн чиглэлээр:

Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Сайнцагаан сумын үржүүлэг технологийн үржлийн аж ахуй нэгж, ХАА-н их сургуулийн МАА-н биотехнологийн оюутнуудын хамтран нутгийн монгол болон суффолк, орхон үүлдрийн эм хонинд Сайнцагаан омог, нарийн нарийвтар ноост орхон, суффолк үүлдрийн хуцны үрээр 500 хонинд зохиомол хээлтүүлэг хийх биотехнологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж буй байдлыг газар дээр нь очиж танилцан, хяналт тавьж илэрч буй алдаа дутагдлыг засаж үйл ажиллагааг сайжруулахаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 сарын А/473 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан удирдамж, аймгийн Засаг даргын А/558 дугаар захирамжийг үндэслэн 13160 хуц, 10695 ухна, нийт 23895 богийн хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх явцад хяналт тавьж ажилласан. Хяналтаар аймгийн хэмжээнд ангилагч шинжээчийн эрхтэй мал зүйч дутагдалтай хүрэлцээгүй, цөм сүргийн ангилалд тэнцсэн буюу үржлийн шаардлага хангаагүй хээлтүүлэгчийг ялгаж тэмдэгжүүлэх ногоон, улаан ээмэггүй, шаардлага хангасан хээлтүүлэгчийг тэмдэглэх шар ээмэгний дутагдалтай хүрэлцээгүй байгаа дутагдал сумдад нийтлэг илэрч байна.

5. Төрийн байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулж, “E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлдэг зорилтын хүрээнд Хүнсний

***ДӨРӨВ.ҮЙЛДВЭР ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
2023 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН***

Нэг. Хүнс, хоол үйлдвэрлэл худалдааны салбарын чиглэлээр хийсэн ажил:

Аймгийн боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 74 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлдэг бөгөөд энэ онд 1,2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос үйлдвэрлэлт 16,6 хувиар өссөн байна.

Хүнсний 4 чиглэлийн 23 үйлдвэр цех үйл ажиллагаа явуулж /талх нарийн боов, мах, сүү, савласан ус/ 85 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрлэлийн хүчин чадлынхаа 90 хувийг ашиглаж байна.

“Хүнсний хангамж аюулгүй байдал”-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд хүнсний үйлдвэрлэлийг дэмжих “Хөрөнгө оруулалт”-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар Сайнцагаан, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумын хүнс үйлдвэрлэгч 9 ААнэгж хүсэлт өгсний дагуу ХХААХҮЯамны ХҮБХЗохицуулах газарт мэдээллийг хүргэж улмаар аймгийн арилжааны банкнуудад үйлдвэрлэгчдийн мэдээлэл ирж зээл судлуулах эрхтэй

болсноор одоогийн байдлаар ХААН банкнаас Мандалговь Хүнс ХХК -245,0 сая, Жаргалант сор ХХК -320,0сая, ХАС банкнаас Элбэг Дэнж ХХК -30,0, нийт 595,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдан үйлдвэрлэлээ өргөтгөн ажиллаж байна.

Мөн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хоршоо хөгжүүлэх сангаас “Сүү боловсруулах-3, “Мал төхөөрөх” мах ангилж савлах, борц, бууз, банш үйлдвэр цех байгуулах -5, талх нарийн боов-1, Хөмүүл даршлах-1, махны зоорины-2 нийт 7иргэн 5 аж ахуйн нэгжийн төсөлд 642 440 000 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлээ.

Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн- 258,8 тонныг үйлдвэрлэж – 10,2 хувийг, бууз банш-15,3 тонныг үйлдвэрлэж -0,9 хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн –3,3 мян.л-ийг үйлдвэрлэж -0,14 хувийг, өндөг -78,4 тонныг үйлдвэрлэж 28 хувийг, төмс-223 тонныг үйлдвэрлэж, 13.3 хувийг, хүнсний ногоо-179.5 тонныг үйлдвэрлэж 5 хувийг тус тус хангасан байна. Гол нэрийн 6 нэр төрлийн бүтээгдэхүүний нийт 57,5 хувийг хангасан байна.

Сайнцагаан сумын “Жаргалант сор” ХХК-ны Тахианы аж ахуй 2 дах жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж, “Говь” нэрийн 78,4 тонн өндөг үйлдвэрлэн хүн амын хэрэгцээнд нийлүүлэн, хэрэгцээт өндөгний 28 хувийг хангасан байна.

жишсэн дундаж хүн амын тоо

№	Бүтээгдэхүүний нэр	Жишсэн нэг хүний хүнсний хоногийн хэрэгцээ /гр/	Жишсэн дундаж хүн амын жилийн хүнсний хэрэгцээ/кг/	Жишсэн дундаж хүн амын жилийн хүнсний хэрэгцээ/тн/
1	малын мах	120	43.8	1675.3
2	загас	30	10.9	416.9
3	шувууны мах	40	14.6	558.4
4	сүү үнээний сүү 3.2% тос	160	58.4	2233.7
5	цагаан идээ /тараг/	180	65.7	2512.9
6	гурил	100	36.5	1396
7	гурилан бүтээгдэхүүн	180	65.7	2512.9
8	төрөл бүрийн будаа	50	18.2	696.1
9	төмс	120	43.8	1675.3
10	хүнсний ногоо	260	94.9	3629.8
11	буурцагт ургамал	40	10.9	416.9
12	жимс, жимсгэнэ	200	73	2792.1
13	өндөг	20	7.3	279.2
14	ургамлын тос	23	8.3	317.4
15	цөцгийн тос-72% тослог	10	3.6	137.6
16	сахар, чихрийн зүйл	33	12	458.9

Гол нэрийн 16 хүнсний бүтээгдэхүүний хангамжийг орон нутгийн үйлдвэрлэл болон худалдаанд байгаа хүнсний бүтээгдэхүүний хэмжээгээр улирал бүр тооцон ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүний нөөц, үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдрүүдэд 15 сумын мэргэжилтнүүд 12 нэр төрлийн хүнсний нөөцийн мэдээг /foodsupply.mofa.gov.mn/ веб дээр суурилсан программд оруулж, сумдын нэгтгэл дүнгээр нийт 98 хүнсний дэлгүүрийн мэдээгээр ХХААХҮЯ-д 48 удаа хүргүүлсэн.

Мандалговь Хүнс ХХК-ны “Сүүн бүтээгдэхүүн”-ий цех нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Тус цех нь энэ онд сүүн бүтээгдэхүүнийг шингэн сүүнд шилжүүлснээр 3,3 мян,л сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж ингэний хоормог 0,3 тн, хорхой ааруул 0,3 тн-ыг тус тус үйлдвэрлэж эрүүл ахуй, чанар стандартын шаардлагад нийцсэн сав баглаа боодолтой хүн амын хэрэгцээнд нийлүүлж байна.

Аймгийн төвийн жишсэн дундаж 13410 хүн амын жилийн хэрэгцээнд 587,3 тн мах хэрэгцээтэй бөгөөд 90 хоног буюу /4-6 сар/ 144,8 тн мах хэрэгцээлэх тооцоо судалгаа байна. Дээрх хэрэгцээнд нийлүүлэх махыг Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч иргэн ААНэгжүүд өөрийн хөрөнгөөр, стандартын шаардлага хангасан хөргүүртэй болон гүн хөлдөөх агуулахад 537,5 тн хонь ямааны махыг нөөцөлсөн байна.

Тус аймагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын эрхлэн явуулж буй бүтээгдэхүүн үйлчилгээнд стандартын хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий аймгийн орон тооны бус баталгаажуулалтын зөвлөл ХХААГ, МХГ, СХЗХ-ийн холбогдох мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Баталгаажуулалтын зөвлөлийн 12 удаагийн хурлаар нийт 119 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн, худалдаа, болон хоол, хүнс үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд, холбогдох стандарт, шалгуур үзүүлэлтээр тохирлын үнэлгээг хийж, тохирлын гэрчилгээг олгож, баталгаажуулалт хийж ажилласан.

Хоол үйлдвэрлэл, худалдааны салбарын чиглэлээр хийсэн ажил:

Аймгийн хэмжээнд 58 иргэн аж ахуйн нэгж үйл хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаагаас 21 Ресторан, Зоогийн газар, кафе, 37 цайны газар үйл ажиллагаа явуулж эдгээрт 283 хүн ажиллаж байна. Мөн Хүнсний худалдааны чиглэлээр 142 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж эдгээрт 451 хүн ажиллаж байна.

Хоол үйлдвэрлэлийн салбарт 4,7 тэрбум, хүнсний худалдааны салбарт 11,3 тэрбумын борлуулалтын орлоготой ажилласан байна. Дээрх газрууд нь бүгд стандартын шаардлагад нийцсэн, тав тухтай, эрүүл аюулгүй үйлчилгээний орчин нөхцөлийг бүрдүүлж үйл ажиллагааг явуулж байна.

Нийтийн хоол, сургууль, цэцэрлэгийн тогооч нарт технологийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан Бүсийн -1, орон нутагт-4 нийт 5 арга хэмжээг аймгийн Засаг даргын тамгын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Боловсрол шинжлэх ухааны газар аймгийн Тогооч нарын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 206 тогоочийг хамруулан ажиллалаа.

1. Зүүн болон говийн бүсийн тогооч нарын бүсийн тэмцээн,/ нийтийн хоолны болон сургууль цэцэрлэгийн тогооч нар/

2. “Хүүхдийн шим тэжээлт хоол”-ыг шалгаруулах ур чадварын уралдаан,/Сургууль цэцэрлэгийн тогооч нар/
3. “Үйлдвэрийн болон эрүүл ахуйн зохистой дадал”-ын сургалт, /нийтийн хоолны тогооч нарт/
4. “Хүнсний нарийн ногоогоор хийх хоолны технолог”-ийн сургалт /Японы олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа Үдийн хоолны төслийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн тогооч нарт/
5. Аймгийн тогооч нарын зөвлөгөөн, сургалт хэлэлцүүлэг нийтийн хоолны болон сургууль цэцэрлэгийн тогооч нар

Аймгийн Засаг даргын шийдвэрээр 2023 оныг "Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил" болгосонтой холбогдуулан Зоогийн газар, кафе, цайны газрын нийт 23 тогооч нарт 5 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, “Фүүд Трэйнинг Консалтинг” -тай хамтран сургалт хамруулан зохион байгууллаа.

Сургалтаар Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019 стандарт, “Технологийн карт мөрдөх” журам, “Хүнсний ногооны хорогдлын норм тооцох аргачлал”, “Хоолны шим тэжээлийн үзүүлэлт, Илчлэг тооцох аргачлал” “Хоолны газрын эрүүл ахуй”, GMP- Үйлдвэрлэлийн зохистой дадал”, “GHP-Эрүүл ахуйн зохистой дадал” сэдэвт нийт 16 цагийн хичээлээр мэдлэг мэдээллийг өгч ажиллалаа.

Мөн сургалтыг онол дадлага хослуулан тосны шинэлэг чанарыг шалгах, 1 порц хоолны давсны агууламж зэргийг зориулалтын багажаар шалгаж туршиж үзсэн нь тогооч нарын мэдлэгт үр дүн, ач холбогдолтой сургалт боллоо. мөн Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаатай суралцагчдыг танилцуулсан.

"Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд “Зүүн болон Говийн бүсийн Аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан” тэмцээн Сүхбаатар аймагт 2023 оны 3 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан. “Гран при”, Зоогийн газар, кафе, “Хүүхдийн хоол”, “Эмнэл зүй” “Оюутан” зэрэг 5 төрөлд манай аймгийн сургууль, цэцэрлэг, хувийн хэвшлийн нийт 9 тогооч оролцсон.Тус арга хэмжээнд Говь-Сүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хэнтий, Сүхбаатар зэрэг 7 аймгийн 150 хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид ур чадвараараа өрсөлдөж "Хүүхдийн хоолны" төрөлд Сайнцагаан сумын Мандал сургуулийн тогооч А. Отгонцэцэг, 5 дугаар цэцэрлэгийн ахлах тогооч Ш.Өлзиймаа нар "Дэд" байр, 8 дугаар цэцэрлэгийн ахлах тогооч О.Отончимэг, "Гутгаар" байр, "Оюутан" төрөлд Политехникийн коллежийн оюутан А.Батдэлгэр, Б.Цэрэнчунт нар "Гутгаар" байр эзэлж багаараа 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж амжилттай оролцсон.Тэмцээний үеэр "Дартс", Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулагдаж аймгийн тогооч нар гар бөмбөгийн тэмцээнд амжилттай оролцож " Тэргүүн" байр эзэлж алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, “Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах зөвлөмж” төвтэй хамтран “Худалдагч касс”-ын мэргэжил олгох сургалтыг ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэдэд зохион байгууллаа. Уг сургалтад Сайнцагаан, Дэлгэрхангай сумдын 30 худалдагч хамрагдаж, чадамжийн гэрчилгээ авч, төгслөө.

2. Газар тариалангийн салбарт хийж хэрэгжүүлсэн ажил:

Хаврын тариалалтаар нийт 52,3 га-д төмс, хүнсний ногоо тариалсан. Төмс 29 га-аас 222 тн, хүнсний ногоо 22,3 га-аас 179,5 тн-ийг ургац хураан авсан. Аймгийн хэмжээнд энэ онд зуны 145 ш хүлэмжид буюу 13919 м² талбайд тариалалт хийснээр хүлэмжийн тариалалт өмнөх оноос 10 ш буюу 1200 м² талбайгаар шинээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ онд хүлэмжээс 81,8 тн ургац хураан авч, урд онтой харьцуулахад 10,3 тн –оор нэмэгдсэн байна.

2023 онд шинээр 6,5 га-д тариалалт хийж, аймгийн хэмжээнд жимс жимсгэнийн 68,5 га талбайтай болсон байна. Жимс, жимсгэнэ 4,5 тн-ийг хураан авч, урд онтой харьцуулахад 1,7 тн-оор нэмэгдсэн байна. Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжийн чиглэлээр 179.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Шинээр баригдсан хүлэмж 10*30 харьцаатай байна. Ажлын явц 60 хувьтай байна.

Өвлийн хүлэмжид 1780 м.кв тариалалт хийсэн. Урд онтой харьцуулахад 140 м.кв нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 19,02 тн-ийг хураан авсан байна.

Энэ онд ойн зурвас шинээр байгуулсан Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт сумын нийт 2 га талбайд 1700 ширхэг /Улиас, хайлаас, Агч, сухай / мод бутыг тариалсан байна. Тариалангийн талбайг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд нийт 57 га-д ойн зурвас бүхий мод бут тариалсан байна.

"Дундговий ногооруулъя" үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа

“Дундговий ногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын тамгын газар, Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хот тохижуулах газар хамтран “Дундговий ногооруулъя” үзэсгэлэн худалдааг 5 сарын 11,12-ний өдрүүдэд Мандал худалдааны төвийн гадна талбайд зохион байгууллаа. Уг үзэсгэлэн, худалдаагаар 17-р нэр төрлийн төмс, хүнсний ногооны үр,үрсэлгээг тарих, арчлах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан борлуулалтын хийж, газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөмжийн үйлчилгээг үзүүлж ажиллана

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих” төслийн нэгжтэй хамтран Сайнцагаан сумаас сонгогдсон “Мандал”, “Говийн Ирээдүй” сургуулийн үдийн хоолны хангамжид төмс, хүнсний ногоо нийлүүлэх 10 ногоочин сонгож, хаврын тариалалтын зориулан нэн шаардлагатай үр болон гар багаж, хүлэмжийн тоног төхөөрөмж зэрэг нийт 10,5 сая төгрөгийн үнэ

бүхий багажийг хүлээлгэн өгч, төмс хүнсний ногоог тариалж, үдийн хоолонд хүнсний ногоо нийлүүлсэн.

ЕБС-ийн “Үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд Сайнцагаан сумын Мандал, Говийн ирээдүй сургуулиудад төмс, хүнсний ногоо нийлүүлэхээр сонгогдсон 10 ногоочдыг Улаанбаатар, Төв, Сэлэнгэ, Дархан аймаг тариалангийн бүс нутгийн тэргүүний тариаланч иргэн, аж ахуйн нэгжүүдийн сайн туршлагатай танилцах, уулзалт аяллыг Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас санаачлан хамтран зохион байгуулсан.

Дээрх арга хэмжээний хүрээнд дэвшилтэт технологийг нутагшуулсан байдал, Хөдөө аж ахуй зохистой дадал”-ыг хэрхэн нэвтрүүлэх, Өвөл, зуны аль ч улиралд ч хүлэмжийн аж ахуй эрхлэх боломж нөхцөлийн талаар мэдээлэлтэй болсон

“Жимс жимсгэнийн суулгац үржүүлэг”-ийн төв байгуулсан

“Хүнсний хангамж аюулгүй байдал”-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Орон нутагт жимс, жимсгэнийн ТШ/2023/ Суулгац плантаци тендер, Багц-1”-ийг зарлаж тендерийн гүйцэтгэгчээр “ЭМ ЖИ ДИ” ХХК шалгарч, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрыг түшиглүүлэн Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төв байгуулсан.

Дээрх жимс, жимсгэнийн суулгац, үржүүлгийн плантацийг байгуулахад улсын төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Орон нутгийн зүгээс “Жимс, жимсгэнийн суулгац, үржүүлгийн төв байгуулах ажлыг дэмжин Сайнцагаан сумын 4-р багт 3 га газрыг шийдвэрлэж өгсөн.

Гүйцэтгэгч “ЭМ ЖИ ДИ” ХХК нь орон нутгийн жимс жимсгэнийн эх ургамлын плантаци байгуулах ажлыг 2023 оны 06 дугаар сарын 19 -ний өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 26 -ний өдрийн дотор гэрээнд заасны дагуу амжилттай хэрэгжүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуйн газарт 3 га талбай бүхий жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн плантаци байгуулах ажлыг хүлээлгэн өгсөн. Үүнд: 1.5 метр өндөр төмөр хашаа 700 метр, техникийн нөхцөлийн дагуу цахилгаан эрчим хүчний хангамжийг хэвийн явуулах 1150м цахилгааны утас татаж 40 см гүнд булсан. Гүний худаг - 1 ш, усны сав 20 тонн 1 ш, 120 м² нийлэг хальсан хүлэмж 2 ш, 4*6 хэмжээтэй агуулахын байр, 3*8 хэмжээтэй зөөврийн орон сууц, мотоблок, анжис, роторт сийрүүлэгч, гар багаж хүрз -5ш, секатор -2 ш, хайч-2 ш, өвс хадагч 1 ш /бензин мотортой/, улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс жимсгэний суулгац 1500 ширхэг, нийт модны талбайд дуслын усалгааны төхөөрөмжтэй холбогдсон бөгөөд нийт 2375 ш мод жимс, жимсгэний суулгацыг суулган хүлээлгэн өгсөн.

3. Жижиг дунд үйлдвэрийн салбарын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

1.Жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, үр дүнгийн гэрээг газрын даргатай байгуулан холбогдох тайлан мэдээг тухай бүр гарган ажиллалаа. 2022 оны жижиг, дунд үйлдвэртэй холбоотой баримтыг үдэж архивт хүлээлгэн өгсөн.

2.Адаацаг сумын малчин эмэгтэйчүүдийн дунд зохиогдсон чуулга уулзалтад "Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол, аюулгүй байдал" сэдэвт сургалт зохион байгуулж нийт 149 хүн хамруулсан.

3.Уламжлалт эко савны үйлдвэрлэл эрхлэгч ТЭББЭ ХХК нь 5000 ширхэг хувин үйлдвэрлэн зах зээлд борлуулж нийт 750,0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. ТЭББЭ ХХКомпани нь 2002 онд байгуулагдсан. Тус компани нь гэрийн модон эдлэл үйлдвэрлэдэг. 2008 онд “Дундговь түншлэл – 2008 “ орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний уламжлалт үзэсгэлэн худалдаанд оролцож “Нэг суурин - нэг бүтээгдэхүүн “ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд амжилт гарган “ Шилдэг үйлдвэрлэгч байгууллагаар” шалгарч байсан. Гэрийн модон тавилга, натур тавилга үйлдвэрлэж байгаад 2013 оноос модон хувин үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2014 онд Дундговь түншлэлээр “ Шинийг санаачлагч байгууллага” 2016 онд Дундговь аймгийн “Шилдэг үйлдвэрлэгч байгууллага” аар, 2022 оны “Шилдэг татвар төлөгч”-өөр шалгарсан.

4.Аймгийн Засаг даргын 2023 оны 05 сарын 22-ны өдрийн А/322 тоот захирамжаар байгуулагдсан Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл орон даяар нэгэн зэрэг цахимаар хүлээн авсан. Манай аймагт энэ онд улсын төсвөөс 1,1 тэрбум төгрөгийн дүнтэй ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хуваарилагдсанаас 1,9 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 19 төсөл хүсэлт ирүүлсэн.

Төслийн зарыг Аймгийн Засаг даргын тамгын газрын болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын пейж хуудсаар хүргэн ажилласан. Мөн Дундговийн амьдрал сонин болон Монголын үндэсний телевизэд мэдээлэл, зарыг хүргэсэн.

[\(2\) ЖДҮХС-ААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ... - Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар | Facebook](#)

2023 оны 03 сарын 22-25-ны өдөр бичиг баримтын иж бүрдэл шалгах шатыг хийж 14 төсөл иж бүрдэл тэнцэн дараа шатанд тэнцсэн.

Жижиг, дунд үйлдвэрийн газраас нарийвчилсан судалгаа хийх шатыг 2023 оны 5 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд ажилласан.

Нарийвчилсан судалгаа хийх ажлын хэсгийн үнэлгээнд:

- Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 228,3 сая төгрөг хүссэн 3 төсөл,
- Хүнсний ногооны зоорь барих чиглэлээр 338,4 сая төгрөгийн санхүүжилт бүхий 3 төсөл,
- Оёдлын үйлдвэрийн чиглэлээр 100,0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 1 төсөл,
- Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр 80,0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 1 төсөл,
- Хүлэмжийн аж ахуйн чиглэлээр 229,5 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 2 төсөл,
- Мал эмнэлэгийн үйлчилгээ 149,3 сая төгрөгийн 2 төсөл,

- Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр 398,9 сая төгрөгийн 2 төсөл тус тус хамрагдан нарийвчилсан шатанд 11 төсөл тэнцсэн.

[\(2\) ЖИЖИГ, ДУНД... - Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар | Facebook](#)

Аймгийн Засаг даргын 2023 оны А/322 дугаар захирамжаар батлагдсан дэд хороо 6 сарын 14-ны өдөр хуралдаж нарийвчилсан шатнаас шалгарсан 11 төслийг хэлэлцэж, эрэмбэлэн Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүллээ.

Төслүүдийг салбараар нь авч үзвэл:

- Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх 2,
- Хүлэмжийн аж ахуйн 1
- Хүнсний ногооны зоорь 3
- Мал эмнэлгийн үйлчилгээний чиглэлийн 2
- Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1
- Эрчимжсэн мал аж ахуй 2 төсөл тус тус шалгаран холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн.

[\(2\) ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР... - Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар | Facebook](#)

1 дүгээр ээлжинд 10 төсөлд 1,100,0 сая төгрөг, 2 дугаар ээлжинд 1 төсөлд 99,4 сая төгрөгийг хувиарласан. Энэ онд ХХААХҮЯамны сайдын тушаалаар 2-р ээлжийг санхүүжүүлэхээр болсон.

2023 онд ЖДҮХСангаас 11 ААНэгжид 1,199,400,000 төгрөг олгосон байна.

№	Харилцагчийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Батлагдсан зээлийн хэмжээ	Хадгалагдсан ажлын байр	Шинээр бий болсон ажлын байр
1	Урам кидс ХХК	Оёмол бүтээгдэхүүн	90,000,000	5	2
2	Дэлгэр номт ундраа ХХК	Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах	90,000,000	1	2
3	Оргио баян хошуу ХХК	Хүнсний ногооны зоорь	38,500,000	1	1
4	Очир-Эрдэнэ дэвжих ХХК	Хүнсний ногооны зоорь	90,000,000	1	2
5	Цутгуурч ХХК	Эрчимжсэн мал аж ахуй	90,000,000	1	2
6	Эрхэст-ундарга ххк	Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах	242,640,000	5	2
7	Мандахговь ХХК	Хүнсний ногооны зоорь	180,000,000	2	4
8	Өлзийсүмбэрэл ХХК	Мал эмнэлгийн үйлчилгээ	50,000,000	2	1
9	Мөнгөлөг мд ХХК	Хүлэмжийн аж ахуй	179,500,000	1	2
10	Жасын Их	Мал эмнэлгийн	49,360,000	1	2

	хонгор ХХК	үйлчилгээ			
11	Холбоо бумбан ХХК	Эрчимжсэн мал аж ахуй	99,400,000	1	2
Нийт дүн			1,199,400,000	21	22

5.“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөний дагуу Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/512 тоот тушаалаар дараах салбар, чиглэлд хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн.

Манай аймагт Жимс, жимсгэнийн төрөлжсөн аж ахуй, Нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгох салбар батлагдсан. Төслийг 2023 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 09:00 цагаас 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 23:59 цаг хүртэл Жижиг, дунд үйлдвэрийн газрын <https://sme.gov.mn/login> цахим хаягаар хүлээн авсан.

Дээрх төсөлд Сайнцагаан сумын “Арвих Их сан” ХХК нь “Жимс, жимсгэнийн төрөлжсөн аж ахуй”-н байгуулахаар 210,0 сая.төгрөгийн төсөл хүргүүлсэн. Өмнөх 2 шатны шалгаруулалтад тэнцсэн. Жижиг, дунд үйлдвэрийн газраас 11 сарын 11-ний өдөр ажлын хэсэг ажиллаж нарийвчилсан шатны шалгаруулалтыг хийсэн. Хариу нь одоогоор гараагүй байна.

https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid02ePjVrqCunSgSAgMT5tvfNEVcfzbKjXCWtPwGWwAqneaYrZ7JBi8H8NqvM34MMqjCI&id=100076045924978&mibextid=YxdKMJ

6.Жайка Олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа Үдийн хоолны загвар төсөлд сонгогдсон Мандал, Говийн Ирээдүй сургуулийн хоол, хүнсний хангамжид орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 10 иргэн Бууцай, чинжүү, хулуу сонгино зэрэг 4 нэр төрлийн хүнсний ногоог нийлүүлж байна. Төрийн байгууллагад орон нутгийн үйлдвэрлэгч 8 иргэн ААНэгж 8 нэр төрлийн нийт 668,3 сая.төгрөгийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж байна.

7. Монгол банкны мэдээллийн санд 15 сумын нийт 610 иргэн, ААН-ийн мэдээллийг шивж оруулсан. 15 сумын 68 зээлдэгчийн мэдээллийг хэвийн ангилалд шилжүүлэн Монгол банканд амжилттай дамжуулсан.

8. Хоршоо хөгжүүлэх сангаас энэ онд 10 сумын 68 иргэн, аж ахуйн нэгжид 1,312.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Ингэснээр 85 ажлын байр хадгалагдаж, 73 ажлын байр шинээр бий болсон байна. Зээлийн эргэн төлөлтийн хувь 45.5 хувьтай байна. Хугацаа хэтэрсэн муу зээлдэгчийн тоо 106 байсныг 50 хувь бууруулан ажилласан байна.

Сайнцагаан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлд орж ажилласан. 2023.06.13-ны өдөр ИТХ-ын Хоршоог хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл 2023 онд Хоршоог хөгжүүлэх сангаас зээл авсан хоршоо, ЖДҮ, үйлчилгээ

эрхлэгчдийн төсөл хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай очиж танилцаж, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт хийж зөвлөмж гарган ажилласан.

https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid09nWHpA4GLRbJ3SmKNfWeLa6Ldnbrdhp2jygqx82qWBG8vHhPdVGU8Jn8BbHH196I&id=100068863314451&mibextid=YxdKMJ

9. 1 сарын 19-2 сарын 19-ны хооронд Улаанбаатар хотын Шинэ зуун айл төвд болсон үзэсгэлэн худалдаанд Сайнцагаан сумын үйлдвэрлэл эрхлэгч Ж.Сарнай, Ц.Отгонцэцэг, Эрдэнэдалай сумын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч Хулан, Луус сумын малчин Баатар нар оролцсон. 8,6 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан.

9 сарын 21, 22-ны өдрүүдэд болсон “Дундговь түншлэл - 2023” үзэсгэлэн худалдаанд 14 сумын 102 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч оролцож, хоёр өдрийн турш 75 гаруй сая төгрөгийн борлуулалт хийжээ. Үзэсгэлэн худалдааны үеэр аймгийн онцлох, шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээ шалгарууллаа. Үүнд: Шилдэг зохион байгуулалттай сум: - Дэлгэрцогт сум Шилдгийн шилдэг гран при - Ш.Бөндөгхорол /Эрдэнэдалай сум/ Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн - С.Дэлгэржаргал /Луус сум/ - Д.Батцэцэг /Дэрэн сум/, - М.Намсрай /Гурвансайхан сум/ - Ж.Батсайхан /Адаацаг сум/ Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн - Д.Тунгалаг /Сайнцагаан/ - Б.Цэндмаа /Баянжаргалан сум/ Шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн - “Урам кидс” ХХК /Сайнцагаан сум/ Шилдэг гар урлалын бүтээгдэхүүн - Ц.Баатар /Сайнцагаан сум/ Шилдэг орон нутгийн онцлогтой нийтийн хоолны үйлдвэрлэл - “Ээлт бор хайрхан” ХХК /Сайнцагаан сум/ Шилдэг хүнсний бүтээгдэхүүн - “Анар Ивээл” ХХК /Эрдэнэдалай сум/ нар тус тус шалгарсан.

10. Бизнес эрхлэгчдийг дэмжих жилийн хүрээнд НҮБ-ийн Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хамтарсан санхүүжилтээр Дундговь аймгийн Сайнцагаан суманд баригдсан “Борлуулалтын цэг” нь 2 дахь жилдээ тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн өмчит Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрээр 180 гаруй иргэн, ААНэгжийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. Энэ жилийн борлуулалтын орлого нь 348.0 сая төгрөг байна.

<https://www.facebook.com/profile.php?id=100066904331504&sk=photos>

11. Энэ онд орон нутгийн хөгжлийн сангаар хуучнаар МСҮТөвийн байрны нэг хэсгийг засварлан бизнес хөгжлийн төв болгосон. Түрээсийн өндөр төлбөр төлдөг иргэн, ААНэгжүүдийг урсгал зардлаа төлдөг ажлын байртай болгосноор үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлсэн.

Бизнес хөгжлийн төвд 4 аж ахуй нэгж, 16 бизнес эрхлэгч нийт 20 хүнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулж, үйл ажиллагааг тогтвортой явуулах, бизнесийг нь өргөжүүлэх зорилгоор шинээр нээгдсэн бизнес хөгжлийн төвд бойжуулж байна. Бизнес хөгжлийн төвд бойжиж буй 20 иргэн, ААНэгж нь нийт 223.3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна.

<https://www.facebook.com/groups/3456864474629042>

11.ХХААХҮЯамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран Бизнес эрхлэгч нарт хоршоо хөгжүүлэх сан болон хоршооны тухай ерөнхий ойлголт, хоршоо байгуулагдсанаар давуу талын талаарх сургалтыг 4 удаа 173 иргэнд зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй 98 хоршоо байна. Хоршоодын 40 хувь нь мал аж ахуй түүхий эд бэлтгэл, 4 хувь нь Мал, эмнэлгийн үйлчилгээ, 2 хувь нь модон эдлэл үйлдвэрлэл, 24 хувь нь ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 8 хувь нь Хадгаламж, зээл, 17 хувь нь худалдаа, үйлчилгээ, 5 хувь нь газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Эрдэнэдалай сумын Далайн баялаг төгөл хоршоо нь Далайн шим болон Арвижих гэсэн 2 малчны бүлэгтэй. Бүлгүүд нь Хүнсний ногоо, сүү цагаан идээ, ногоон тэжээл тариалсан. Үүнээс Хүнсний ногоо болон Сүү, цагаан идээгээ борлуулан хоршооны дундын сандаа 3,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2023 оны 06 сарын 02 өдөр Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоотой хамтран ХАА-н хоршоологчдын холбооны 15-р бага хурлыг зохион байгуулж бага хуралд нийт 10 сумын 31 хоршооны төлөөлөл оролцлоо.

6 сарын 29-ны өдрөөс 7 сарын 1-нд Хоршоологчдын туршлага судлах аялалд Сайнцагаан сумын Бялхам дүүрэн баяр хөөр хоршоо, Говь-Угтаал сумын Говь-Угтаал сумын Угтаал ундрам ХЗХ, Загийн алим эко хоршоо, Эрдэнэдалай сумын Далайн баялаг төгөл хоршооны нийт 4 төлөөлөл хамрууллаа.

7 сарын 30-ны өдрөөс 08 сарын 02-ны өдрүүдэд Гурвансайхан суманд "Хоршоодын шинэчлэл-Хөгжлийн шинэ эхлэл" сэдэвт хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөн болсон. Зөвлөгөөнд Баян-Өлгийг аймгаас бусад 20 аймгийн төлөөлөл нийт 200 гаруй хоршоологч нар цуглаж өнгөрсөн жилд хийсэн ажилаа дүгнэн мөн Хоршоодын шинэчлэл хөгжлийн шинэ эхлэл сэдвээр зөвлөлдөн харилцан туршлага солилцсон үр дүнтэй арга хэмжээ болсон.

12. "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК-с Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн дагуу бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, биржээр арилжих тогтолцоог бий болгох, хоршооны бараа, түүхий эдийг худалдан авагч, үйлдвэрүүдэд арилжих зорилгоор Хоршоодын төлөөлөл болон орон нутгийн мах бэлтгэн нийлүүлэгч иргэн, ААНэгжтэй уулзалт зохион байгуулсан.

Монголын Хөдөө Аж Ахуйн Биржийн ахлах мэргэжилтэн Р.Алтай, ахлах мэргэжилтэн В.Мөнхнэмэх, мэргэжилтэн Т.Мөнхболор, аймгийн ХААХХолбооны дарга Д.Чандмань нарын бүрэлдэхүүнтэй баг Дундговь аймагт ажиллаж Адаацаг сумын Амьдралын туг, Дэрэн сумын "Наран хөгцтий", "Цантын хаяа", Сайнцагаан сумын "Аривжих далай", "Аривжуулагч", "Бялхам дүүрэн", Луус сумын "Шинэ хөдөлмөр" зэрэг хоршоод дээр очиж үйл ажиллагаатай нь танилцан ХАА-н биржийн байнгын бус гишүүнээр бүртгэн гэрээ байгуулсан, мөн хоршоодын агуулах сав болон Сайнцагаан суман дээрх махны хөргүүр бүхий зоориудын зураглалыг гаргаж биржийн итгэмжлэлийг 3 жилийн хугацаатай олгох гэрээ байгуулсан. Энэ арга хэмжээнд ХАА-н хоршоологчдын холбооны гишүүн 7 хоршоо, махны хөргүүр бүхий агуулахтай 3 иргэн хамрагдсан.

13. Ахуй үйлчилгээний салбар 173 иргэн, ААНэгж 238 иргэнийг ажлын байраар ханган үйл ажиллагаа явуулж байна.

Явуулын ахуйн үйлчилгээ шаардлагатай сумдын судалгааг авсны дагуу 6 дугаар сарын 15-16-ны өдөр Дэрэн сумын ард иргэдэд үзүүлсэн.

Ахуй үйлчилгээг дараах салбараар үйлчилгээ үзүүллээ. Үүнд: - Оёдол засвар - Гутал засвар - Үсчин - Гоо сайхан - Хумс, засал - Утас засвар Нийт давхардсан тоогоор 120 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж 2,1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.

14. 3 дугаар сарын 28-ны өдөр Хөдөө аж ахуйн ажилчдын зөвлөгөөн зохион байгуулсан. Зөвлөгөөнд сумдын мэргэжилтэн нарт зөвлөгөө өгсөн. Мөн зөвлөгөөний бүртгэлийг хийж оролцсон.

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА

Ж.ШИНЭ-УЯНГА